

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН

2012



АГУУЛГА

1. КОМПАНИЙН ТУХАЙ

- Компанийн товч танилцуулга 5
- Компанийн засаглал 6
- Компанийн нийгмийн хариуцлагын бодлого 7
- 2012 оны онцлох үйл явдал, ололт амжилт 8

2. ОРОЛЦОГЧ СОНИРХОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Орон нутгийн иргэдийн оролцоог хангах 11
- Оролцогч талуудын хамтын ажиллагаа 11
- Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх механизм 13

3. АЖЛЫН БАЙР, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА

- Ажлын байр 14
- Сургалт, хөгжил 15
- Хөдөлмөрийн аюулгүй байдал 15
- Нийгмийн хамгаалал, халамж 16

4. БАЙГАЛЬ ОРЧИН

- Байгаль орчны суурь судалгааны ажил 19
- Өнгөн хөрсний хамгаалалт, хадгалалт ба үржил шимт хөрс 19
- Биологийн болон техникийн нөхөн сэргээлт 19
- Хог хаягдлын менежмент 21
- Байгаль хамгааллын тухай сургалт 22

5. НИЙГЭМ, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БҮЙ ХУВЬ НЭМЭР

- Татвар төлөлт 23
- Нийгэм, орон нутагт оруулсан хөрөнгө оруулалт 24
- Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд 27

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид орчин үеийн техник технологийг мэргэшсэн боловсон хүчний ур чадвар, хүсэл тэмүүлэлтэй хослуулан Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулна.

АЛСЫН ХАРАА

Бид олон улсын зах зээл дээр нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн борлуулах дэлхийн хэмжээний үйл ажиллагаатай үйлдвэрлэгч компани болно.



1. КОМПАНИЙН ТУХАЙ



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Энержи Ресурс ХХК нь 2005 оны 4 дүгээр сарын 22-нд байгуулагдсан үндэсний уул уурхайн компани юм. Манай компани нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаа Худаг коксжих нүүрсний ордод 2009 оны 4 дүгээр сараас олборлолт хийж эхэлсэн бөгөөд 2962 га талбай бүхий, 11952А ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

Ухаа худаг орд газрын байршил:

- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвөөс 8 км
- Аймгийн нийслэл Даланзадгад хотоос зүүн тийш 90 км
- УБ хотоос өмнө зүгт 540 км
- Монгол – Хятадын хилээс 245 км
- Оюутолгой зэс – алтны ордоос 150 км

Компани нь Монгол Улсын хөгжил, дэвшил, үйлдвэржилт, шинэчлэлд өөрсдийн бодитой хувь нэмрийг оруулах, сайн чанарын коксжих нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүнээр олон улсын зах зээлд өрсөлдөх эрхэм зорилготойгоор ажиллаж байна. “Монгол”-оор овоглосон тэргүүлэгч зэргийн коксжих нүүрсний брэндийг бий болгож, бус нутгийн төдийгүй дэлхийн зах зээлд таниулах зорилтын хүрээнд бид үйл ажиллагааныхаа үе шат бүхэнд олон улсын стандартыг мөрдлөг болгодог.

Өнгөрч буй хугацаанд Энержи Ресурс компани уурхай, боловсруулах үйлдвэр болон дагалдах дэд бүтцийн төслүүдэд нийт нэг их наяд гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн (хүснэгт 1-ээр томоохон хөрөнгө оруулалтын дүнг харуулав) төдийгүй 2009-2012 оны байдлаар татвар, шимтгэл хэлбэрээр 346,7 тэрбум төгрөгийг орон нутгийн болон улсын төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт.1 Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын дүн

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Хөрөнгө оруулалтын дүн /тэрбум төгрөг/
1	Нүүрс баяжуулах үйлдвэр (10 сая тн)	427
2	Авто зам (Ухаа худаг- Гашуун сухайт чиглэлд 245 км)	157
3	Цахилгаан станц (18 мегаватт), ус хангамж	165
4	Төмөр зам	84
5	Бусад	230
Нийт хөрөнгө оруулалтын дүн		1,063

Манай компани нь орон нутгийн иргэдтэй сайн хөршийн харилцааг хөгжүүлж, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар олон нийтийн санал бодлыг бүхий л үйл ажиллагааны явцад тусгаж ирсэн бөгөөд жил бүр нэг тэрбум гаруй төгрөгийг орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, чадавхижуулах төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулж байна.

Төсөл урагш ахихын хэрээр орд газрын геологийн загварчлалыг сайжруулахын хажуугаар олборлолтын дэвшилтэт шинэ арга технологиудыг нэвтрүүлэн, бүтээмжийг тасралтгүй сайжруулах зорилт тавин ажиллаж байна. Уурхайн үндсэн үйл ажиллагаа болох нүүрс олборлолт, хөрс хуулалт болон мэргэжлийн ажилчдын сургалт, дадлагажуулалт зэрэг чиглэлүүдэд компани Австралийн Лейтон Ази компанийг гүйцэтгэгчээр ажиллуулж байгаа төдийгүй нүүрс баяжуулах үйлдвэрийг шинээр барьж байгуулах ажилд боловсруулах үйлдвэрлэлийн технологи, дизайн болон менежментийн чиглэлд дэлхийд тэргүүлэгч, Австралийн Сежмен компанийтай хамтарч ажилласан.

Ухаа Худаг уурхайн дэд бүтцийн төслүүдийг хөгжүүлэх ажилд мэргэжлийнхээ чиглэлд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Parsons Brinckerhoff, Wilbur Smith Associates, Aquaterra зэрэг нэр хүндтэй компаниудтай хамтарч, орчин үеийн шилдэг, шинэ туршлагуудыг нэвтрүүлж байна.

Мөн Ухаа Худаг төслийн хүрээнд дотоодын нийт 700 гаруй байгууллага, аж ахуйн нэгжтэй туслан гүйцэтгэгч, бэлтгэн нийлүүлэгч хэлбэрээр идэвхтэй хамтран ажиллаж байна. Нийгмийн хариуцлага, байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлтийн бодлого болон орон нутгийн тогтвортой хөгжилд оруулах бидний хувь нэмэр Энержи Ресурс компанийн урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөний салшгүй хэсгийг бүрдүүлж байдаг.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн сайн засаглал нь Энержи Ресурс компанийг ажиллуулах, удирдах, хяналтыг хэрэгжүүлэх үзэл баримтлал гэж бид үздэг, иймд:

- Энержи Ресурс компани нь олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.
- Энержи Ресурс компани нь компанийн засаглалын соёлыг байгууллагынхаа хөгжлийн салшгүй хэсэг болгон мөрдөнө.

Компанийн хувь нийлүүлэгчид, Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) болон гүйцэтгэх удирдлага нь компанийн эрхэм зорилго, алсын хараа, эрхэм зүйлс, зорилтуудад компанийн сайн засаглалын олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, компанийн засаглалын соёлыг байгууллагынхаа хөгжлийн салшгүй хэсэг болгон мөрдөх талаар тусгаж баталгаажуулсан. Эдгээр зарчмууд компанийн үйл ажиллагааны үе шат бүрт тусгалаа олж, компанийн өмчлөгч, удирдлагууд болон ажилтан нэг бүрийн даган мөрдөх хэм хэмжээ болон мөрдөгдөх ёстой гэж бид үздэг.

Энержи Ресурс компани нь дотоодын болон олон улсын хэмжээнд мөрдөгддөг, сайн засаглалын шаардлагуудыг биелүүлэн ажилладаг төдийгүй нээлттэй, ил тод, хариуцлагатай байдал, шийдвэр гаргалтын энгийн, түргэн шуурхай орчныг бүрдүүлэхүйц байдлаар дотоодын дүрэм, журмуудын хэрэгжилтийг хангадаг.

Энержи Ресурс компани нь шинээр байгуулагдсан Монголын Компанийн Засаглалыг Хөгжүүлэх Төвд гишүүнээр элсэж, төвийн үйл ажиллагааг жигдрүүлэхэд чиглэсэн Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран зохион байгуулсан компанийн засаглал, үнэлгээний аргачлалын сургалтуудад идэвхтэй оролцож ирлээ.

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО

Энержи Ресурс компанийн хувьд Компанийн Нийгмийн Хариуцлага (КНХ) гэх ойлголтыг дан ганц хандив, тусламж, богино хугацааны төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх хязгаарлагдмал хүрээнд авч үздэггүй бөгөөд олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхан, улс орны эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах замаар ирээдүйн тогтвортой хөгжлийн бат бэх суурийг бий болгохоор зорьж ажилладаг.

Компани нь хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэхэд туштай ажиллаж байгаа ба Олон Улсын Стандартын байгууллагаас 2010 оны 10-р сард гаргасан ISO26000 Нийгмийн хариуцлагын зөвлөмж болон Олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудаас гаргасан удирдамжуудад үндэслэн КНХ-ын бодлогоо боловсруулсан.

Уг бодлогод "Энержи Ресурс компани нь Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулахдаа компанийн нийгмийн хариуцлагын тухай олон улсын стандарт, олон улсын санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны шаардлагууд болон Монгол Улсын холбогдох хууль, журам, стандарт, зарчмуудыг хүлээн зөвшөөрч, тэдгээрт нийцүүлсэн үйл ажиллагааг нээлттэй, ил тод явуулж, хүний эрх, хөдөлмөрийн шударга харилцаа, бизнесийн ёс зүйг дээдлэн хэрэгжүүлнэ" хэмээн заасан.

Компанийн нийгмийн хариуцлага гэдэг нь өөрийн байгууллагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэрийн нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөний талаар бүрэн хариуцлага хүлээх, нийгмийн сайн сайхан, тогтвортой хөгжлийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ил тод нээлттэй явуулах, бизнесийн ёс зүйг эрхэмлэн дээдлэх, бизнест хамааралтай оролцогч

тaluудын хүлээлт, ашиг сонирхлыг хүндэтгэх, хууль болон олон улсын бизнесийн норм, хэм хэмжээг эрхэмлэн сахих, байгууллагынхаа үйл ажиллагааг гадаад орчинтой нягт уялдуулан зохицуулах явдал юм.

Компанийн зүгээс хийж хэрэгжүүлж буй төсөл, үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийж төслийн сонирхогч талууд болон олон нийтэд танилцуулдаг.

Энэхүү үнэлгээний төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжүүлэлтийн явцад эерэг нөлөөллийг дэмжин, сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор тодорхой шат дараатай арга хэмжээг авч, төслийн сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө, олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээлэл түгээх төлөвлөгөө, байгаль орчин нийгмийн менежментийн төлөвлөгөө, өргөдөл гомдол барагдуулах журам, соёлын өвийн менежментийн төлөвлөгөө, олон нийтийн эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө зэрэг менежментийн төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэн ажилладаг.

Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, нийгмийн суурь бүтцүүдийг тогтвормжуулахад дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд дэд бүтэц, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, боловсролыг дэмжих, соёлын өвийг хамгаалах, жижиг дунд бизнесийг дэмжих үндсэн чиглэлүүдээр төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна.

Хөтөлбөр, төслийн хүрээнд иргэд, оролцогч талуудтай зөвлөлдөх, компанийн үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээллийг түгээх, орон нутгийн иргэд, оролцогч талуудаас ирсэн санал гомдлыг барагдуулахад анхааран ажилладаг.

Хүний эрх, аюулгүй байдлын сайн дурын зарчмуудыг Энержи Ресурс компани мөрдөн ажилладаг төдийгүй үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй ажиллагсад ба орон нутгийн иргэдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, хүний эрхийн чиглэлийн сургалт, хөтөлбөрүүдийг тогтмол зохион байгуулж ирсэн.

2012 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ, ОЛОЛТ АМЖИЛТ

Өнгөрсөн жил уул уурхайн салбар үүсч хөгжсөний 90 жилийн ой тохиосонтой холбогдуулан Энержи Ресурс компаниас олон бүтээлч ажлуудыг өрнүүлж, хэрэгжүүллээ.

2012 оны 2-р сард Ухаа худаг уурхайн төслийн хүрээнд Монголын анхны Нүүрс баяжуулах үйлдвэрийн 2-р модулийг ашиглалтад оруулж, дотоодын боловсруулах үйлдвэрлэлийн салбарт томоохон хөрөнгө оруулалт хийлээ. Ингэснээр Ухаа худагийн Нүүрс баяжуулах үйлдвэрийн жилийн боловсруулалтын хүчин чадал 10 сая тоннд хүрсэн. Үйлдвэрийн 3-р модуль 2013 онд ашиглалтад орно.

Компани усны ууршилт, нэвчилт буюу алдагдлыг бүрэн хязгаарласан усан сан,.govь нутагт нэн зохимжтой, усны "0" хэрэглээ бүхий хуурай хөргөлтийн системтэй цахилгаан станцын технологи, үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усыг 98% хүртэл эргүүлэн ашиглах

технологи, усны ашиглалтыг хянах орчин үеийн телеметрийн удирдлагын систем гэх зэрэг орчин үеийн дэвшилтэй технологиудыг Монголын уул уурхайн салбарт анх удаа нэвтрүүлсэн бөгөөд уг үзүүлэлтээр Монгол Улсын Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас (БОНХЯ) Green Awards 2012 буюу “Ногоон” манлайллын эздийг тодруулсан арга хэмжээний Ус хэмнэгч, зөв зохистой хэрэглээний технологийг нэвтрүүлэгч номинацид шалгарч, тэргүүлсэн. Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинг нэн тэргүүнд анхаарах зорилт тавин ажилладаг. Уурхайн үйл ажиллагаа өргөжихийн хажуугаар /2012 онд нүүрс олборлолтын хэмжээг 8.6 сая тоннд хүргэсэн/ хөдөлмөрийн аюулгүй байдлын стандарт шаардлагуудыг өндөр түвшинд ханганд ажиллаж байна. 2012 оны байдлаар 1,000,000 цаг ажиллахад гарсан хөдөлмөрийн чадвар түр алдалт /LTIFR/-ыг 1.4-өөс 0.75 болтол бууруулж чадсан. Энэ үзүүлэлт нь уул уурхайн салбарын хөгжлөөр тэргүүлэгч Австралийн Queensland мужийн LTIFR буюу олон улсын дундаж үзүүлэлтээс бага байгаа гэдэг утгаараа маш амжилттай үзүүлэлт юм.

Энержи Ресурс компани нь ажиллагдынхаа нийгмийн асуудлыг нь анхаарч, тав тухтай, тогтвортой суурьшилтай ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлж, Өмнөговь аймгийн Цогтцэций суманд орон сууцны Цэций хорооллын 2-р ээлжийг ашиглалтад оруулснаар шинээр нийт 192 өрх иж бүрэн тавилгатай, орчин үеийн тохилог орон сууцанд орсон. Мөн Өмнөговь аймагтай хамтарсан хөрөнгө оруулалтаар “Мөрөөдөл” нэртэй орчин үеийн сургууль, цэцэрлэг, дотуур байрны цогцолборыг Цогтцэций суманд байгуулж, ашиглалтад оруулсан. Энэхүү бүтээн байгуулалт нь өдөр тутмын үндэсний хэвлэл “Өглөөний сонин”–оос зохион байгуулсан олон нийтийн санал асуулгаар 2012 оны үндэсний шилдэг бүтээн байгуулалтаар тодорлоо.

Энержи Ресурс компани нь 2012 оны ажлын үзүүлэлтүүдээрээ Монголын уул уурхайн салбарын мэргэжлийн, хараат бус шалгаруулалт болох Mongolian Mining Journal awards 2012-т хамгийн өндөр оноо авч, Гран при шагналын эзнээр мөн Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас жил бүр зохион байгуулдаг үндэсний шилдэг аж ахуйн нэгж тодруулах Интерпренер шалгаруулалтын “ТОП -10” аж ахуйн нэгжийн нэгээр дөрөв дэхь жилдээ тус тус шалгарлаа.

Түүнчлэн Энержи Ресурс компани нь жил бүр дэлхийн 500 гаруй корпораци материалыа өгдөг нийгмийн хариуцлагын чиглэлээр зохион байгууллагддаг Global CSR award олон улсын шалгаруулалтад оролцож, мөнгөн медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн юм.



2. ОРОЛЦОГЧ СОНИРХОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Энержи Ресурс компани нь оролцогч, сонирхогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөг 2009 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү төлөвлөгөө нь дараах үндсэн зарчмуудыг тусгасан байдаг.

- Орон нутгийн иргэд Ухаа Худаг төслийн талаар мэдээлэл хүртэх эрхээ эдлэх эрхтэй;
- Компани нь бодлого, төлөвлөлтөндөө сонирхогч талуудын санал хүсэлтийг тусгах зарчмыг баримтлан үр дүнтэй хэлэлцүүлгийг аливаа шахалт дарамтгүйгээр, шударгаар явуулах үүрэгтэй;
- Үйл ажиллагааныхаа нийт хугацааны туршид сонирхогч талуудын оролцоог хангах үйл ажиллагааг тогтмол явуулах
- Иргэдийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх механизмыг бий болгон хэрэгжүүлэх;

Компанийн олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээлэл түгээх төлөвлөгөөний хүрээнд үйл ажиллагаанаас үүдэн гарах эерэг, сөрөг нөлөөллийн талаар орон нутгийн иргэдэд үнэн зөв, бодит мэдээлэл өгөх, тэдгээрийн санаа зовж буй асуудалд хариу өгч холбогдох арга хэмжээ авч байхаар тусгасан байдаг.

Энэ дагуу 2012 онд Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх асуудлаар гурван сумын нөлөөллийн бүсийн малчидтай хэлэлцүүлэг, уулзалт зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт нөлөөллийн бүсийн Баян-Овоо сумын 33 өрх, Ханбогд сумын 29 өрх, Цогтцэций сумын 8 өрх нийт 70 өрхийн 88 гишүүд оролцож, төмөр замын төслөөс

үүдэн гарах эерэг, сөрөг нөлөөллийг хэлэлцсэн бөгөөд малчдын олонхи нь байгаль орчны болон нийгэм эдийн засгийн давуу талуудыг харгалзан үзэж, уг төслийг дэмжиж байгаагаа илэрхийллээ.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ОРОЛЦОOG ХАНГАХ

Бид КНХ, хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг мөрдлөг болгож, хүний эрхийг дээдлэх, сонирхогч талуудын идэвхтэй оролцоог хангах, шударга, нээлттэй, ил тод байх зарчмуудыг баримтлан ажилладаг. Компани байгуулагдсан цагаасаа хойш нийт 6 удаагийн Нээлттэй хэлэлцүүлэг, өдөрлөгийг Өмнөговь аймгийн 5 сумыг хамран зохион байгуулж, малчид орон нутгийн иргэд, төр, төрийн бус байгууллагуудад мэдээлэл хүргэж, харилцан санал солилцож ирснээс гадна тэдний санал, зөвлөмжүүдийг үйл ажиллагаандaa тусгасаар ирсэн.



Мөн орон нутгийн иргэдтэй нээлттэй харилцааг хөгжүүлж, шийдвэр гаргах явцад тэдний оролцоог хангах, дуу хоолойг тусгах үүднээс Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдад орон нутгийн сайн дурын зөвлөл байгуулан тууштай хамтран ажиллаж байна.

Компаниас тус зөвлөлүүдтэй сар бүр уулзаж, хэлэлцдэг бөгөөд зөвлөл нь 9-11 хүний бүрэлдэхүүнтэй малчид, өрх толгойлсон эмэгтэйчүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гишүүд, иргэний нийгмийн байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадын төлөөлөл зэрэг нийгмийн бүхий л төлөөллийг хамруулсан байдаг. Ингэснээр зөвлөл нь нутгийн иргэдийн дуу хоолой болж, тэдний санал зөвлөмжийг компанийд уламжлах замаар компани болон иргэдийн хооронд нээлттэй, эрх тэгш оролцоотой байх, хамтын ажиллагаа хөгжих боломжийг нэмэгдүүлж байна. 2012 онд зөвлөлийн бүрэлдэхүүнээ дахин сонгосон бөгөөд сар бүр хуралдаж компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авах болон малчдын гаргасан нийт 27 санал, гомдлыг хэлэлцсэн байна.



Түүнчлэн, байгаль орчны хяналт шинжилгээ, аюулгүй байдалд малчидтай хамтын ажиллаагааг эрхэмлэдэг бөгөөд 2012 онд авто зам дээр ажиглалт, хяналт хийх, байгаль орчинд хог хаягдалгүй байлгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр орон нутгийн 32 малчин иргэдийг ажлын байраар хангаж хамтран ажиллаж байна.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Оролцогч, сонирхогч талуудын хамтын ажиллагааг бий болгох, бэхжүүлэх, мэдээлэл түгээх зорилгоор бие даасан менежментийн төлөвлөгөөг боловсруулан шат дараатай,

төлөвлөлттэй хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Компани нь оролцогч болон сонирхогч талуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг бий болгох, мэдээлэл туршлага солилцох, үйл ажиллагаандын хөндлөнгийн мониторинг үнэлгээ хийлгэх, үйл ажиллагаагаа тайлгнах зэргээр гадаад дотоодын олон байгууллагатай үр өгөөжтэй хамтран ажиллаж байна.

Уул уурхайн экспертуудээс туршлага судлах хөтөлбөр



Монгол Улсад уул уурхайн байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ой 2012 онд тохиосонтой холбогдуулан үе үеийн уул уурхайн туршлага бүхий ахмад экспертуудээс туршлага судлах хөтөлбөрийг 7 сарын турш амжилттай зохион байгууллаа. Хөтөлбөрт Геологи уул уурхайн сайд асан, техникийн ухааны доктор Ч.Хурц, Эдийн засгийн ухааны доктор, профессор, МУИС-ийн геологи, газарзүйн сургуулийн багш С.Авирмэд, ШУА-ийн гишүүн, ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, академич, химийн шинжлэх ухааны

доктор (Sc.D), профессор Б.Пүрэвсүрэн нарын уул уурхайн тэргүүлэгч 8 эксперт, эрдэмтэд оролцож, Ухаа худаг уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцаж, заавар зөвлөгөө өгөхийн зэрэгцээ уурхайн ажиллагсадтай нийт 5 удаагийн цувралт, сургалт семинар зохион байгуулсан.

Уг арга хэмжээний хүрээнд экспертууд Ухаа худаг уурхайд ажиллаж, амьдарч буй уурхайчин залууст уул уурхайн холбогдох сэдвүүдээр илтгэл тавьж, уурхайчин залуучуудын сонирхсон асуултанд хариулт өглөө. Мөн уг хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн Таван толгойн уурхайн бүтээн байгуулалтанд ажил, амьдралаа зориулсан ахмад уурхайчдад хүндэтгэл үзүүлж уурхайн даргаар олон жил ажилласан н.Хүүхэнжав, тэргүүний уурхайчин н.Санжаадамба, н.Дуламсүрэн нарын нийт 13 ахмадыг Ухаа худагийн уурхайд хүлээн авлаа. Хөтөлбөрт оролцсон бүх ахмадууд, экспертууд Ухаа худаг уурхайн бүтээн байгуулалттай танилцаж, Ухаа худгийн уурхайчин залуустай ажил амьдралын арвин баялаг туршлагаасаа хуваалцахын зэрэгцээ орчин үеийн техник технологи, эрдэм мэдлэгээр үндэсний их бүтээн байгуулалтыг цогцлоож байгаад нь баяр хүргэлээ.

Орон нутгийн харилцааны ажилтнуудын туршлага солилцох уулзалт

Уул уурхайн компаниуд хоорондын харилцан мэдээлэл, туршлага солилцох, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Өмнөговь аймгийн уул уурхайн компаниудын Орон нутгийн харилцааны ажилтнуудын нөхөрсөг уулзалтыг Энержи Ресурс компаниас санаачлан Өмнөговь аймгийн Уул уурхайн Ассоциацтай хамтран хоёр дахь жилдээ зохион байгууллаа. Уг уулзалтанд тус аймагт уул уурхайн чиглэлээр ажилладаг нийт 15 компанийн 53 төлөөлөгч оролцсон. Хоёр өдөр үргэлжилсэн уг уулзалтын үеэр оролцогчид өөрсдийн компанийн үйл

ажиллагааны талаар танилцуулан, мэдээлэл солилцохын зэрэгцээ тус компаниудын орон нутгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр, тэргүүн туршлага болон орон нутагт үзүүлж буй нийгмийн эерэг, сөрөг нөлөөллийн тулгамдаж буй асуудлуудын талаар хэлэлцүүлэг өрнүүллээ. Уг арга хэмжээнд Θмнөговь аймагт үйл ажиллагаа явуулдаг MAK, Хүннү Ресурс, Оюутолгой, Treasure mountain international mining , ЭНК , Эрдэнэс таван толгой, Таван Толгой ХК, BOLD FUER-DA , Таван Толгой Транс, Шинэ Лонгда, Reabody Winsway Resources, Зэлэм, Олон Овоот гоулд, Дун Юань, Си Ай Эс зэрэг компаниуд холбогдох төлөөллөө оролцууллаа.



ӨРГӨДӨЛ ГОМДЛЫГ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ

Компанийн үйл ажиллагааны улмаас хүний эрх, эрүүл мэнд, аюулгүй байдалд мөн байгаль орчинд үүсч болзошгүй аливаа сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлж цаг тухайд нь арга хэмжээ авч байх зорилгоор орон нутгийн иргэдээс ирсэн гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэх ба гомдол гаргагчдад эргэн мэдээлдэг журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2012 онд нийт 25 гомдол хүлээн авснаас шийдвэрлэсэн 22, шийдвэрлээгүй 3 байна. Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлуудыг сумдаар ангилбал Баян-овоо сумаас 7, Ханбогд сумаас 7, Цогтцэций сумаас 11 өргөдөл гомдол ирснээс 36% нь бэлчээр талхлат, худаг ус, замын асуудал хөндсөн, 44% нь нүүлгэн шилжүүлэх, нөлөөллийн бүсэд орох санал тавьсан, 10% нь хамтран ажиллах ажлын санал ирүүлсэн мөн 10% нь уурхайн сөрөг нөлөөллөөс үүдсэн хохирол барагдуулахыг хүссэн байлаа. 2011 онтой харьцуулахад компанийд хандах гомдлын тоо 26.4 хувиар буурсан үзүүлэлт гарч байна. Компанийн үйл ажиллагаа явуулж буй сумдад байгуулагдсан Орон нутгийн зөвлөлийн гишүүд иргэдийн өргөдөл, гомдол барагдуулах ажилд хамтран оролцож иргэдэд журмын зорилгыг таниулан мэдээлж хамтран ажиллаж байна. Үүний үр дүнд орон нутгийн иргэдээс компанийн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг үр дагаварыг илрүүлж мэдээлэхээс илүү хандив, тусlamжийн хүсэлт гаргадаг байсан чиг хандлага өөрчлөгдөж уг журмын зорилгыг ойлгон бидэнтэй хамтран ажиллаж байна.




3. АЖЛЫН БАЙР, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА



АЖЛЫН БАЙР

Ухаа Худаг уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойших дөрвөн жилийн хугацаанд асар эрчтэй өрнөсөн бүтээн байгуулалт, ажлын далайцаас шалтгаалан ажиллагсдын тоо хурдацтай өсч Цогтцэций суманд шилжин суурьших ажиллагсдын тоо ч нэмэгдсээр байна. Энэ утгаараа компанийн зүгээс тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, шилжин суурьших нөхцөлийг бүрдүүлэх, хувь хүний болон мэргэжлийн хувьд тасралтгүй өсөн дэвжих боломжийг бүрдүүлэхэд онцгой анхаарч, хүний нөөцийн бодлогодоо тусган ажиллаж байна.

Энержи Ресурс компанийн хэмжээнд үйл ажиллагаа эхлүүлсэн эхний жил буюу 2009 онд 639 ажлын байр, 2010 онд 491 ажлын байр, 2011 онд 765 ажлын байр тус тус шинээр бий болгосон бол 2012 оны 12-р сарын эцсийн байдлаар 395 гаруй ажлын байрыг шинээр бий болгожээ. Мөн нийт Ухаа худаг төслийн бүтээн байгуулалтын хүрээнд 8,000 гаруй хүн шууд болон шууд бус ажлын байраар хангагдаж байна



Компанийн үндсэн ажиллагсдын тоо 2012 оны байдлаар 2500 гаруйд хүрсний 36 хувийг орон нутгийн иргэд тодруулбал Өмнөговь аймгийн Цогтцэций, Даланзадгад, Манлай, Баян Овоо, Цогт-Овоо сумын иргэд зонхилон бүрдүүлж байна.

Хүснэгт 2. Ажиллагсдын судалгаа

Үзүүлэлт	2011/12/31	2012/12/31
1. Нийт ажиллагсдын тоо	2177	2568
2. Эмэгтэй ажиллагсдын тоо	348	449
3. Удирдах түвшний эмэгтэй ажиллагсдын тоо	14	22
4. Орон нутгийн ажиллагсдын хувь	30%	36%

СУРГАЛТ, ХӨГЖИЛ

Ажиллагсдадаа шаардлагатай мэргэжлийн ур чадвараа сайжруулах, хувь хүний ерөнхий ур чадварыг нэмэгдүүлэх, болон байгууллагын соёлыг төлөвшүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна. Сургалтын хэрэгцээг илүү бодитой тогтоох, ажиллагсдын ур чадварыг бодитой үнэлэх нэг арга хэрэгсэл болох ур чадварын үнэлгээний стандарт загвар, аргачлалыг бий болгон нийт ажлын байрны 50 орчим хувьд нь боловсруулан бэлтгэв.

Цахилгаан станц, ус хангамж, хот төлөвлөлт, хүнд машин механизм гээд чиглэл тус бүрд мэргэшүүлэх сургалтуудыг хийж, шаардлагатай тохиолдлуудад гадны байгууллагуудаас мэргэжилтнүүдийг урьж оролцуулж байна. Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах бодлого баримталж, уурхайн сургалтын албандаа нутгийн залуусыг хүнд даацын автомашины оператороор мэргэшүүлэн сургаж байна. 2010 оноос эхлэн хүнд машин механизмын засварчин бэлтгэх зорилгоор 8-10 сарын цалинтай сургалтыг Вагнер Ази компанийтай хамтран зохион байгуулж эхлээд байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 130 залуус сургалтанд хамрагдан техникийн мэргэшсэн засварчин болоод амжилттай ажиллаж байна.



2012 оны байдлаар тус компани давхардсан тоогоор нийт 1293 ажиллагсадыг 163 төрлийн сургалтанд хамруулаад байгаа бөгөөд үүнээс 647 ажиллагсад ерөнхий ур чадварын, 646 нь мэргэшүүлэх сургалтанд хамрагджээ.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Хариуцлагатай уул уурхайн үүргээ ухамсарлан, "Аюулгүй байдлыг хангасны дараа ажлаа эхэльье" уриатайгаар ажилладаг бөгөөд нийт ажилтан ажиллагсадаа эрүүл аюулгүй орчинд ажиллуулахаас гадна, өөрийн үйл ажиллагааны хүрээнд оролцож буй бүх талуудын аюулгүй байдлыг хангаж ажилладаг.



Энержи Ресурс компанийн Хөдөлмөрийн Аюулгүй Байдлын нэгж нь Ухаа Худаг төслийн хүрээнд Байгаль Орчин, Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Ахуйн Удирдлагын Тогтолцоог Олон улсын стандарт “ISO 14001: 2004 Байгаль Орчны Удирдлагын Тогтолцоо”, “OHSAS 18001: 2007 Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуйн Удирдлагын Тогтолцоо”—ны шаардлагад нийцүүлэн нэвтрүүлж, хэрэгжүүлж, хэвшүүлэхээр төлөвлөлт, баримт бичгийн боловсруулалт,

бүрдүүлэлтийн шатандаа явж байгаа бөгөөд 2013 онд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Түүнчлэн тус компанийн онцгой байдлын алба нь уурхайн олборлолт, үйлдвэрлэлээс үүдэх осол, аваараас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах ажиллагааг хангахаас гадна иргэдийн шуурхай дуудлагад орон нутгийн онцгой байдлын хэлтэс, цагдаагийн тасагтай хамтран ажиллаж байна.

Цогтцэций сумын иргэдийн орон сууц, гэр, машин техниктэй холбоотой галын дуудлага, зам тээврийн осол, хүн машинд хавчигдсан зэрэг ослын тохиолдолд орчин үеийн аврах тоног төхөөрөмж, багажыг ашиглан хүний амь насыг аврах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, иргэдийн өмчийг авран хамгаалах, эд хөрөнгө, өмчийн хохирлыг бууруулах зэрэг арга хэмжээг шуурхай авч ажиллаж байгаа ба 2012 онд нийт 6 галын ослын дуудлага болон 2 үерийн дуудлагад ажилласан байна.

Тус 2012 оны хувьд зуны улирал хур бороо ихтэй байснаас Цогтцэций сумын иргэд хоёр удаагийн хүчтэй аадар бороо, үерт нэрвэгдэж ихээхэн хэмжээний өмчийн эвдрэл, хохирол учирсан бөгөөд Энержи Ресурс компанийн аврагч, гал сөнөөгчид үерт нэрвэгдсэн 89 айлын эд хөрөнгийг авран хамгаалж, түр нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулсан.

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХАЛАМЖ

Ажиллагсад, боловсон хүчин манай компанийн амин чухал зүйл гэж бид үздэг билээ. Иймд ажиллагсад болон тэдний гэр бүлийг Өмнөговь аймгийн Цогтцэций суманд шилжин суурьшиж богино хугацаанд дасан зохицож, хэвийн ажиллаж амьдрах, шилжин суурьшсанаар сэтгэл хангалуун байх нөхцөл бололцоог бүрдүүлэх зорилгоор Цэций хорооллын орон сууцыг ажиллагсадад нөхцөлт урамшууллын хэлбэрээр олгох бодлого боловсруулан хэрэгжүүлж байна. 600 айл, өрх амьдрах орчин үеийн энэхүү орон сууцны хороолол нь усан оргилуур, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт оршин суугчдын тав тухтай амьдралын хэрэгцээ шаардлагыг хангасан тохилог сууцны жишиг болж байгаагаараа онцлогтой. Мөн орон нутгийн болон шинээр шилжин суурьшсан ажиллагсаддаа зориулж Цогтцэций сумын

төвд нэгдсэн зохион байгуулалтаар хашаа, гудамж, гэрэлтүүлэг, худаг гээд дэд бүтцийг нь бүрэн шийдсэн 370 өрх амьдрах “Уурхайчин” нэртэй жишиг гэр хороолол байгуулаад байна.

Түүнчлэн ажиллагсадын шилжин суурьшилт бусад уул уурхайн үйл ажиллагааг дагаад Цогтцэций сумын хүн ам өсөн нэмэгдэж, 2012 оны байдлаар тус сумын хүн ам 5180 болж хөдөлгөөнт хүн ам нийлээд 10,000 гаруй болжээ. Иймд хүн амын төвлөрлийг дагаад нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжгүй байдал буй болж буйг судлан Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран 2012 онд “Мөрөөдөл” нэртэй сургууль, цэцэрлэг, дотуур байрны иж бүрэн цогцолборыг ашиглалтанд орууллаа.

Цогцолбор нь нэг ээлжиндээ сургууль 650, цэцэрлэг 144, дотуур байр 100 хүүхдийн багтаамжтай бөгөөд ажиллагсадын болон орон нутгийн иргэдийн хүүхдүүдийн боловсролыг хөгжүүлэх жишиг сургалттай болох зорилго тавин ажиллаж байна.



4. БАЙГАЛЬ ОРЧИН



Энержи Ресурс компани үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг зохистой ашиглахыг зорилго болгон нөхөн сэргээх ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжууд болон олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, байгаль орчны стандартуудыг мөрдөж ажилладаг.

Байгаль орчны менежментийн систем нь компанийн үйл ажиллагаанаас бий болох сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн байдаг. Ухаа Худаг уурхайд хог хаягдал, ус, хөрсний элэгдэл эвдрэл зэрэг чиглэлүүдээр төрөлжсөн менежмент төлөвлөгөөнүүдийг боловсруулж, хэрэгжүүлж байна. Оролцогч талуудын чухал төлөөлөл болох орон нутгийн иргэдийн байгаль орчны мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургуулийн сурагчид болон нутгийн малчид, иргэдэд ойжуулалт, зүлэгжүүлэлт, хог хаягдлын менежмент, байгалийн нөөцийн зохистой ашиглалтын талаар сургалт явуулдаг. Түүнчлэн орчны хяналт шинжилгээнд нутгийн иргэдийг оролцуулж, тэднээр хөндлөнгийн хяналт хийлгэдэг.



Хяналт үнэлгээний ажилд иргэдийг оролцуулж буй байдал

БАЙГАЛЬ ОРЧНЫ МОНИТОРИНГ

Манай компанийн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үүсч буй нөлөөллийг хянах зорилгоор ус, хөрс, ургамал ба амьтан, агаарын чанаарын хэмжилт, мониторингийг байгаль орчны мэргэжлийн байгууллага болон эрдэмтэн судлаачидтай хамтран гүйцэтгэдэг. Мониторингийн ажлын тайланг жил бүр БОНХЯ-д хүргүүлж, хянуулдаг.

ӨНГӨН ХӨРСНИЙ ХАМГААЛАЛТ, ХАДГАЛАЛТ БА ҮРЖИЛ ШИМТ ХӨРС

2012 онд байгаль орчны чиглэлээр үржил шимт хөрс сайжруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүллээ.

1. Хөрсний мониторингийн судалгаа
2. Өнгөн хөрс хуулахад зориулж үржил шимт давхаргын зузааныг тодорхойлох хээрийн судалгаа
3. Хөрсний төлөв байдал, үржил шимиин үзүүлэлтийг тодорхойлох лабораторийн туршилт
4. Байгаль орчны нөхөн сэргээлтийн туршилтын талбайн хөрсийг био-ялзмаг, гумины бордоо, шувууны сангасаар бордолт
5. Хамгаалалтын ойн зурvasын хөрсний чийг хангамж, био-ялзмаг, гумины бордоо, шувууны сангасаар бордолт
6. Хаягдлын чuluулгын овоолгын нөхөн сэргээлтийн талбайд био-ялзмаг, гумины бордоо, шувууны сангасаар бордолт
7. Үржил шимт хөрсний овоолгын ургамалжуулалт
8. Үржил шимт хөрсний менежмент төлөвлөгөө боловсруулах зорилгоор ажлын даалгаврыг бэлдэн, мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага, эрдэмтэн судлаачдаас санал цуглуулсан байна.

БИОЛОГИЙН БОЛОН ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Биологийн нөхөн сэргээлтэнд зориулан мод, бут сөөг, нутгийн ургамал болон наст ургамлыг туршилтын журмаар ургуулан тухайн бүс нутагт зохицсон ургамлыг сонгон шалгаруулж, улмаар үржүүлэн нөхөн сэргээлт болон орчны тохижилт, ойн зурvas байгуулахад ашиглах зорилгоор Байгаль орчны нөхөн сэргээлтийн туршилтын талбайг 2009 онд байгуулсан. Туршилтын талбай нь дотроо үржүүлгийн хэсэг, эх ургамлын хэсэг, хүлэмж, бойжуулах талбай, хамгаалалтын зурvas, модлог ургамлын туршилтын талбай болон олон наст ургамлын туршилтын талбай гэсэн хэсгүүдтэй. Хайлаас, жигд, сухай, улиас, нарс, гацуур, монос, чацаргана, бургас, заг зэрэг 22 төрлийн 26000 орчим мод сөөг, бутлаг ургамлууд болон хялгана, өлөнгө, хиаг, ерхөг зэрэг олон наст ургамлуудыг ургуулж байна.

Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас үлдсэн хоосон чuluулгыг овоолго үүсгэн үлдээдэг бөгөөд уг хаягдал чuluулгын овоолгыг нөхөн сэргээж ургамалжуулах ажлыг бид 2011 оноос

Эхлэн гүйцэтгэж байгаа бөгөөд 2011 онд 1 га талбай, 2012 онд 2 га талбайд нөхөн сэргээлт хийгээд байна.



Туршилтын талбай



Туршилтын талбайд тарьсан 1 настай заг

Тарилтыг хийхдээ дээр өгүүлсэн ганд тэсвэртэй нутгийн унаган улаан бор бударгана, орог тэсэг, хармаг, хотир,.govийн хялгана, гялгар дэрс зэрэг ургамлууд болон ургамжууд боломжтой саман ерхөг, соргүй согоовор, дагуур өлөнгө зэрэг ургамлуудыг тарьсан.

Хөрсний тогтвортой байдлыг хангахын тулд хөрсний гулсалт, элэгдэл, эвдрэлээс хамгаалах дэвшилтэй технологи болох 3D Геоматт материалыг дэвсэж хөрсөөр хучсан бөгөөд усалгааг хийхдээ усны хэмнэлттэй мини бороожуулагч спринклер системийг ашиглаж байна. Нөхөн сэргээлт хийж буй талбай нь хэдийгээр.govийн хуурай уур амьсгалтай, хур тунадас бага унадаг бүсэд байрлаж буй боловч зуны улиралд үе үе хүчтэй ширүүн бороо ордог тул үерийн ус зайлцуулах систем байгуулах зайлшгүй шаардлагатай басувгуудыг чулуугаар доторлон байгуулж байна.



Хаягдал чулуулгын овоолгын налуулга дээр биологийн нөхөн сэргээлт хийж байгаа нь


ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Баруун нарангийн нүүрсний уурхайгаас Ухаа Худагийн уурхай хүртэл тусгай зориулалтын хатуу хучилттай авто замыг 2012 оны 4 сараас 2012 оны 11 сар хүртэлх хугацаанд гүйцэтгэж

хүлээлгэн өгсөн. Зам барилгын ажилд Ханхонгор сумын нутагт 7 карьер, Цогтцэций сумын нутагт 17 карьер нийт 24 карьер нээн ашигласнаас 23 карьерийн 51 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг дуусгаж орон нутагт хүлээлгэн өглөө. Ингэхдээ хаягдал чулуулгын овоолгыг стандартын дагуу 18 хэмтэйгээр налуулж үржил шимт хөрсийг 30 см-ийн зузаантайгаар хучиж техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэлээ.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Төслийн үйл ажиллагаанаас үүсч буй нийт хог хаягдлыг байгаль орчин нийгэмд үзүүлэх нөлөөллийг нь бууруулах үүднээс системтэйгээр цуглуулж, зайлцуулах нь хариуцлагатай уул уурхайн баримтладаг зарчмуудын нэг юм. Үйл ажиллагаа өргөжихийн хирээр хог хаягдлын үүсэх хэмжээ нэмэгдэж, цаг тухайд нь зохицтойгоор зайлцуулахгүйн улмаас орчны бохирдол ихсэх эрсдэл байдаг. Иймд компанийн зүгээс хог хаягдлын үүсэлтийг бууруулах, дахин ашиглах болон дахин боловсруулах хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, зайлцуулах ажлыг системтэйгээр зохион байгуулж хог хаягдлын менежмент төлөвлөгөөг улам боловсронгуй болгох тал дээр анхаарал тавьж ажиллаж байна.



Уурхайн олборлолт, үйлдвэрлэл, бусад дэд бүтцийн болон ахуйн үйл ажиллагаанаас үүсч байгаа хог хаягдлыг эх үүсвэр дээр нь болон хог хаягдал ангилан устгах цэг дээр төвлөрүүлж, ангилан ялгалт хийх бөгөөд дахин ашиглах боломжгүй хаягдлыг байгаль орчинд аюулгүй байдлаар зайлцуулдаг. Хатуу хог хаягдал ангилан устгах цэг нь ангилан ялгах хэсэг, хуванцар, төмрийн болон бусад дахин ашиглагдах хог хаягдлыг цуглуулах хэсэг, бохирдсон хөрс цуглуулах талбайнуудад хуваагддаг.

2012 онд нийт 1900 ш хаягдал дугуйг хоёрдогч түүхий эдээр ашиглахад зориулсан бөгөөд малчдын худагт эрүүл ахуйн бүс тогтоох зорилгоор хаягдал дугуйг ашиглан хашаажуулсан нь нутгийн иргэдийн сайшаалыг хүртээд байна. Мөн хог хаягдлыг ангилан ялгалтыг сайжруулах, хаягдлыг дахин ашиглах идэвхийг өрнүүлэх зорилгоор Ухаа худаг төслийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй бүх компаниудын дунд “Хог хаягдлын эко шийдэл” уралдааныг нээлттэй зарлан зохион байгууллаа. Уралдаанд хаягдлыг дахин ашигласан

нийт 7 компанийн 12 хүний 50 сонирхолтой бүтээл шалгарсан бөгөөд агаар шүүгчийн тор ашиглан хогийн сав хийсэн, усны савны таглаа ашиглан машины суудлын бүрээс хийсэн мөн барилгын хөөсөнцөр ашиглан бэлэг дурсгалын зүйлс хийсэн нь хаягдлыг баялаг болгож болохын үлгэр жишээ болсон.

Уралдаанд ирүүлсэн бүтээлүүдээс



Агаар шүүгч ашигласан хогийн сав



Хаягдал төмөр болон хөөсөнцөр ашигласан даам, хөлгийн хамт

БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ТУХАЙ СУРГАЛТ

Нутгийн иргэдийн байгаль орчныг хамгаалах тухай ойлголтыг сайжруулах, байгаль орчин хамгаалахад оролцох оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Цогтцэций, Баян-Овоо сумын иргэд, малчид, сурагчдад сургалт зохион байгуулдаг. 2012 онд нийт 622 нутгийн иргэд, сурагчдыг байгаль орчны сэдвээр сургалтанд хамруулсан байна. Цогтцэций сумын Мөрөөдөл дунд сургуулийн 7-10 ангийн, Баян-овоо сумын 9-н жилийн сургуулийн 7-9 ангийн сурагчдад Усны зохистой хэрэглээ ба хог хаягдлын сургалт, Цогтцэций сумын 11-н жилийн сургуулийн 5, 7 ангийн сурагчдад Байгаль хамгаалах Монгол уламжлал, Хөрс хамгаалахын ач холбогдол сэдвээр тус тус сургалт зохион байгууллаа.

Хүснэгт 4. Байгаль орчны чиглэлээр орон нутагт зохион байгуулсан сургалтууд

Сургалтын нэр	Сургалтанд хамрагдсан нэгж	Оролцогчдын тоо
Мод тарих, ундны усны эрүүл ахуй, хог хаягдлын хор нөлөө, нийтийн бие засах газрын ариутгал зэрэг сэдвээр сургалт, зөвлөмж	Багийн нийтийн хурал (3 баг тус бүрт)- Цогтцэций сум	110
Усны зохистой хэрэглээ	Цогтцэций сумын дунд сургуулийн сурагчдад	70
Усны зохистой хэрэглээ	Цогтцэций сумын Мөрөөдөл сургуулийн сурагчид	123
Усны зохистой хэрэглээ ба хог хаягдлын хор нөлөө	Баян овоо сумын дунд сургуулийн сурагчдад	65
Хөрс хамгаалал	Цогтцэций сумын дунд сургуулийн сурагчид	68
Хог хаягдал	Цэций хорооллын оршин суугчид	18
Байгаль орчны мониторинг	Цогтцэций сумын иргэдэд	13
Байгаль хамгаалах Монгол уламжлал	Цогтцэций сумын дунд сургуулийн сурагчид	155
Нийт		622

5. НИЙГЭМ, ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ОРУУЛЖ БҮЙ ХУВЬ НЭМЭР



ТАТВАР ТӨЛӨЛТ

Энержи Ресурс компани нь үйл ажиллагаа эхлүүлсэн анхны жил буюу 2009 онд 13 тэрбум төгрөгийг улсын төсөвт төлж байсан бол 2010 онд 54 тэрбум төгрөг, 2011 онд 116.5 тэрбум төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлсэн. Өнгөрч буй 2012 оны тухайд 12 сарын 30-ны байдлаар татвар төлөлтийн дүнг доорхи хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 5. Компанийн татвар төлөлтийн байдал (2012 он)

Ангилал	Дүн
ААОАТ	44,814,419,940
АМНАТ төлбөр	71,924,629,518
Агаарын бохирдлын хураамж	10,162,777,400
Гаалийн хураамж	8,671,846,514
Гаалийн татвар	11,925,247,095
ЭМ,НД шимтгэл	9,070,495,122
ХАОАТ	4,514,252,275
Бусад татвар, хураамж	2,178,214,010
Нийт	163,261,881,874

ОРОН НУТАГТ ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Энержи Ресурс компани нь 2012 онд нийт 29 орчим тэрбум төгрөгийг орон нутгийн хөгжилд зарцуулсан. Үүнд Цэций орон сууцны хорооллын 2-р ээлж болох 192 айлын орон сууц, "Мөрөөдөл" сургууль, цэцэрлэгийн цогцолбор болон орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөр бусад ажлууд багтаж байна.

Хүснэгт 6. Нийгэм, орон нутагт чиглэсэн хөрөнгө оруулалтын нэгтгэл /2012/

Хөрөнгө оруулалтын чиглэл	Дүн (төгрөгөөр)
1. Нийгмийн дэд бүтцийн чиглэлээр:	28,403,603,804
Цэций орон сууцны хороолол (4 блок), Цогтцэций сум	22,945,581,956
Мөрөөдөл сургууль, цэцэрлэг, дотуур байрны цогцолбор, Цогтцэций сум	4,569,500,000
Цахилгаан эрчим хүчээр болон цэвэршүүлсэн ундны усны хангалт (тариифийн хөнгөлөлт, Цогтцэций сум)	320,021,848
Өвлийн хэрэглээний нүүрсний хангалт 37,900 тн (Даланзадгадын ДЦС болон Баян-Овоо, Ханбогд, Ханхонгор сумд)	568,500,000
2. Байгаль орчны чиглэлээр:	102,158,625
Ойн зурvas- Тариалангийн талбай байгуулах эхний 5 га (Нийт 15 га талбай хамрана), Цогтцэций сум	54,535,120
Хог, хаягдлын цэгийн цэвэрлэгээнд 20 тн түлшний зардалд, Цогтцэций сум	47,623,505
3. Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөрүүд:	638,955,839
Боловсролыг дэмжих хөтөлбөр	151,818,198
Эрүүл мэндийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр	37,589,713
Соёлын өвийг хамгаалах, хадгалах хөтөлбөр	149,968,000
ЖДҮ-ийг дэмжих, Малчдын тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр	106,527,928
Өвс тэжээлийн тусlamж (9050 боодол өвс, 2910 шуудай хивэг, 2181 шуудай хорголжин тэжээл) Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд, Ханхонгор сумд	193,052,000
4. Бусад дэмжлэг	181,166,200
НИЙТ	29,325, 884,468

"Цэций орон сууцны хороолол"

Цогтцэций сумын төвд орчин үеийн орон сууцны "Цэций" хорооллыг байгуулж буй бөгөөд 2012 онд уг хорооллын 4 байр шинээр ашиглалтанд орлоо. Ингэснээр нийт 192 айл өрх бүрэн тавилгатай, орчин үеийн тохилог орон сууцанд ороод байна. Энэ хороолол нь усан оргилуур, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт оршин суугчдын тав тухтай амьдралын хэрэгцээ шаардлагыг хангасан тохилог сууцны жишиг болж байгаагаараа

онцлогтой бөгөөд автобусны буудал, үсчин, эмнэлэг, гоо сайхан, халуун ус, супермаркет зэрэг ахуйн үйлчилгээний байгууламжуудыг цогцоор нь байгуулахаар төлөвлөж байна.



“Цэций” орон сууцны хорооллын гадаад харагдах байдал,
тоглоомын талбайн хэсгээс

“Зузаахай” цэцэрлэг

Цогтцэций сумын хүн амын төвлөрлийг дагаад сургуулийн өмнөх боловсрол эзэмших хэрэгцээ улам өссөөр байгааг харгалzan Цэций хорооллын орон сууцанд 140 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 126 хүүхдийн багтаамж бүхий, төлбөртэй, ашгийн бус үйл ажиллагаатай “Зузаахай” цэцэрлэгийг байгуулан 2012 оны 9 сарын 1-нд ашиглалтад оруулаад байна.



Энэ төсөл хэрэгжсэнээр Энержи Ресурс компани болон хамтран ажилладаг бусад компаниудын ажилчид орон нутагт гэр бүлээрээ шилжин суурьших, хүүхдүүд нь цэцэрлэгт сургуулийн өмнөх боловсрол эзэмших, сурч хүмүүжих нөхцлөөр хангагдаж, улмаар санаа зовох зүйлгүй сэтгэл амар, үр бүтээлтэй, тогтвортой суурьшилтай ажлаа хийх боломж бүрдэж байна. Ийнхүү Цогтцэций суманд орчин үеийн сургалтын орчны стандартад нийцсэн тохиолог анги танхим, материаллаг бааз бүхий цэцэрлэг нэгээр нэмэгддэж сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээний хүртээмж сайжирч байна.

“Мөрөөдөл” сургууль, цэцэрлэг, дотуур байрны цогцолбор

Хүн амын төвлөрөл нэмэгдэж байгаа Цогтцэций сумын нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх буюу орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор Энержи Ресурс компани нь 6024 м² талбай бүхий 640 хүүхдийн сургууль, 144 хүүхдийн цэцэрлэг, 725 м² талбай бүхий 100 хүүхдийн дотуур байрны цогцолборыг Өмнөговь аймгийн ЗДТГ-тай хамтран (нийт хөрөнгө оруулалт 6,9 тэрбум төгрөг болсноос Энержи Ресурс компани 56%-ийг санхүүжүүлсэн) санхүүжүүлж “Мөрөөдөл” сургууль цэцэрлэгийн цогцолборыг байгууллаа.



Энэхүү цогцолбор нь сургалтын орчин үеийн стандартыг нэвтрүүлсэн, архитектурын өвөрмөц шийдэл бүхий нэгдмэл төлөвлөлттэй гэдгээрээ онцлог юм. Тус цогцолборыг орон нутагт хүлээлгэн өгөх ба улсын статустай Цогтцэций сумын 6-р сургууль, 7-р цэцэрлэг үйл ажиллагаагаа амжилттай эхлээд байна. Түүнчлэн компанийн зүгээс уг цогцолборын гадаад, дотоод орчны тохижилт, тоног төхөөрөмж нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сурч, хүмүүжих бүхий л нөхцлийг бүрэн хангасан байхад шаардлагатай тоног төхөөрөмж суурилуулахад хөрөнгө оруулалт хийсэн төдийгүй, цогцолбор нь цаашид орон нутгийн боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах боловсролын жишиг сургалтын хөтөлбөр, стандартыг хангасан сургалтын менежментийг нэвтрүүлэх “хөтөлбөр” хэрэгжүүлэх бөгөөд зардлыг компани бүрэн хариуцан ажиллах юм.

“Мөрөөдөл” цогцолборын гадаад харагдах байдал



ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

Компанийн нийгмийн хариуцлага, орон нутгийн харилцааны газраас орон нутгийн нийгмийн нөлөөллийн үнэлгээ, хүн ам, эрүүл мэнд, хүний эрх, соёлын өв зэрэг нийгмийн олон чиглэлийн судалгаа болон иргэдийн нээлттэй хэлэлцүүлгийн санал санаачлагыг үндэслэн орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг тууштай хэрэгжүүлж байна. Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд эдгээр төсөл хөтөлбөрүүдийг орон нутгийн иргэд, олон нийт болон засаг захиргааны байгууллагуудын оролцоотойгоор хамтран хэрэгжүүлсээр ирлээ.

Боловсролыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

“Говийн Ирээдүй” оюутны тэтгэлэгт хөтөлбөр



Компаниас орон нутгийн боловсролыг дэмжих зорилгоор Монгол Улсын их, дээд сургуулиудад амжилттай суралцаж байгаа, Өмнөговь аймгийн харьят, нутагтаа ажиллаж амьдрал өөрийн хувь нэмрээ оруулах ирээдүйн чадварлаг мэргэжилтнүүдийг бэлтгэх “Говийн ирээдүй” оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг дөрөв дэхь жилдээ хэрэгжүүллээ.

2012 оны сонгон шалгаруулалтанд Өмнөговь аймгийн харьят нийт 136 оюутан материалыа ирүүлснээс 3 шатны сонгон шалгаруулалт явагдаж шилдэг 30 оюутныг тодруулан, тэтгэлэг хүртэх батламжийг гардууллаа. Шалгарсан оюутнууд 2012-2013 оны хичээлийн жилийн туршид сар бүр тэтгэлэг хүртэх, компанийн харьяа салбар компаниудад дадлага хийх эрхтэй болсон юм. Энэ удаагийн хөтөлбөрийн онцлог нь орон нутагт нэн тэргүүний хэрэгцээ шаардлагатай мэргэжлийн чиглэлийг харгалзсан бөгөөд Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн саналын дагуу “сургуулийн өмнөх боловсрол олгох мэргэжил”-ээр суралцаж буй оюутнуудыг хөтөлбөрт хамруулахад анхааран ажиллалаа.

"Ирээдүйн Сайн Сайхны Төлөө" тэтгэлэгт хөтөлбөр

Энержи Ресурс компанийн боловсролыг дэмжих бодлогын хүрээнд инженер техникийн мэргэжилтнүүд, уул уурхай, барилга, хими технологи боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлд нарийн мэргэжил эзэмшиж буй оюутнуудыг дэмжих, чадавхижуулах зорилгоор "Ирээдүйн сайн сайхны төлөө" тэтгэлэгт хөтөлбөрийг зохион байгуулсан. Уг хөтөлбөрт хот, хөдөөгийн 20 гаруй их дээд сургуулийн 300 гаруй оюутан бүртгүүлснээс шалгаруулалтанд тэнцсэн нийт 41 оюутан 2012 оны хичээлийн жилд сар бүр 100,000 төгрөгний тэтгэлэг хүртэх эрхтэй боллоо. Мөн уг оюутнуудад суралцах хугацааныхаа туршид болон төгссөнийхөө дараа тус компанийд мэргэжлийн дадлага хийх, ажлын байраар хангагдах боломжийг нээлттэй олгодгоороо онцлогтой юм.

Англи хэлний гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөр

Цогцэций сумын ерөнхий боловсролын дунд сургуулийг англи хэл, математикийн гүнзгийрүүлсэн сургалттай болгох тусгайлсан хөтөлбөрийг 2009 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр 9 жилийн сургалтын хөтөлбөртэй дунд сургууль стандарт буюу 12 жилийн сургалтын хөтөлбөртэй болсноос гадна гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалтын эрхийг албан ёсоор авсан нь хөдөө орон нутгийн сургуулийн сургалтын чанарт ахиц гарах чухал алхам болсон.

Тус хөтөлбөр нь 2009- 2013 он хүртэл нийт 3 жил үргэлжилж буй бөгөөд өнгөрсөн хугацаанд сургууль англи хэлний DynEd олон улсын сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлж, сургалтын орчин кабинет, сурах бичгийг бүрдүүлсэн төдийгүй математик ба англи хэлний өндөр ур чадвартай багш нарыг урилгаар авч ажиллуулжээ.



Мөн хөтөлбөрийн хүрээнд 400 гаруй номтой "English Library буюу Англи хэлний номын сан" ажиллуулсан бөгөөд 2011-2012 оны хичээлийн жилийн турш англи ном унших сурагчдын тоо өсөн нэмэгдэж, хамгийн сүүлчийн тооллогоор англи хэл сурч байгаа 600 гаруй сурагчдын 300 нь тус номын сангийн үйлчлүүлэгчид болсон бөгөөд шилдэг уншигчдаа шалгаруулсан байна.

Түүнчлэн хөтөлбөрийн хүрээнд "ABC Performance буюу Англи цагаан толгойн баяр", "Spelling bee", "Happy mother's day", "English Week буюу Англи хэлний долоо хоног" арга хэмжээг сар бүр зохион байгуулахын зэрэгцээ "Who is the best reader?", "Bookworm", "Big Book Week" зэрэг хүүхэд хөгжүүлэх, сурагчдын англи хэлний мэдлэг, чадварыг таниулах арга хэмжээг зохион байгуулсан нь сурагчдын англи хэл сурах хүсэл, сонирхол, идэвх чармайлтыг нэмэгдүүлж байгаа юм.

Сүүлийн жилүүдэд улс аймгийн чанартай математик, англи хэлний олимпиадуудад Цогтцэций сумын сургуулийн багш, сурагчид тасралтгүй оролцож, тухай бүр өндөр амжилт үзүүлж байгаагаас тус хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж болох юм.

Эрүүл мэндийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд:

Эрүүл мэндийн үзлэг, оношилгоо

Уул уурхай эрчимтэй хөгжиж буй Өмнөговь аймгийн зүүн бүсийн эмч нарын ур чадварыг нэмэгдүүлэх, орон нутгийн иргэдэд эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг ойртуулах, халдварт ба халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зэрэг зорилгоор Эрүүл мэндийн хөтөлбөрийг жил бүр уламжлал болгон Өмнөговь аймаг болон зүүн сумдын эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран гурав дахь жилдээ зохион байгуулж байна.

2012 оны 8 сарын 24-27-ны өдрүүдэд Цогтцэций сумын эмнэлэгт Өмнөд Солонгосын Ewha Womens' University Medical Center, УБ Сонгдо эмнэлгүүд хамтран нийт 13 эмч, сувилагчийн бүрэлдэхүүнтэй баг сумын эмнэлэг, Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газартай хамтран зүрх үе мөч, хавдар, мэс засал, эмэгтэйчүүд, хүүхэд гэсэн чиглэлээр хамтарсан үзлэг оношилгоо хийлээ.



Энэхүү үзлэгт компанийн шилжин суурьшсан ажиллагсад, тэдгээрийн гэр бүл, эмнэлгийн хяналтад байдаг, нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагатай Өмнөговь аймгийн 8 сумын иргэд зэрэг нийт 1214 (давхацсан тоогоор) хүн эрүүл мэндийн үзлэг оношлогоонд хамрагдсан байна. Уг арга хэмжээнд дөрвөн сумын эмнэлгийн 8 эмч оролцсон бөгөөд орон нутгийн эмч нарын тусlamж үйлчилгээний чадавхийг сайжруулах зорилгоор ажлын байран дээр дагалдуулан дадлагажуулах арга хэмжээг зохион байгууллаа. Мөн хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн иргэдийн дунд зонхилж буй өвчин эмгэгт үндэслэн сумдын эмнэлгийг эм тариагаар хангаж, мөн Ewha болон УБ Сонгдо эмнэлэгийн эмч нар хамтран 2 хүнд мэс засал үнэ төлбөргүй хийж гүйцэтгэсэн.

“Эрүүл иргэн - бус нутгийн хөгжил” хөтөлбөр

Уул уурхайн бус нутгийн эрүүл мэндийн төвүүдийн нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлэх, орон нутгийн малчид, иргэдийн эрүүл аж төрөх ойлголт дадал, хэвшил, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Эрүүл иргэн - Бус нутгийн хөгжил” сургалт сурталчилгааны хөтөлбөрийг Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран 2012 оны 10-р сард хэрэгжүүллээ. Уг хөтөлбөрт Өмнөговь аймгийн Баян-Овоо, Манлай, Цогт-Овоо, Цогцэций, Ханбогд, Ханхонгор, Даланзадгад гэсэн 7 сумын харьяа нийт 2773 хүн хамрагдсан. Хөтөлбөрийн хүрээнд нөлөөллийн бүсийн эрүүл мэндийн төвүүдийн сургалт хийх чадавхийг бэхжүүлэх зорилгоор сумдын их, бага эмч, эмнэлгийн ажилчдад сургалт зохион байгуулж, сургалтын материал, техник хэрэгсэл, гарын авлагаар бүрэн хангасан.

Мөн малчид, иргэдэд зонхилон тохиолдох нас баралт, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл дадал хэвшлийг төлөвшүүлэх, зөв хандлага бий болгох, мэдээлэл, сургалт, сурталчилгаагаар хангах зорилгоор сумдын малчин өрх, тээврийн жолооч нар, залуучууд өсвөр үеийнхэн болон сумын төвийн иргэдэд БЗХӨ болон дахин сэргэж буй халдварт өвчлөл, байгалийн гамшиг, ахуйн болон зам тээврийн осол гэмтлээс сэргийлэх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн зан үйл төлөвшүүлэх, халдварын бус өвчлөлөөс сэргийлэх, архи тамхины хэрэглээг бууруулах, зөв зохистой хооллох, хөдөлгөөнийг эрчимжүүлэх зэрэг чиглэлээр эрүүл мэндийн сургалтуудыг зохион байгуулсан.

Соёлын өвийг хамгаалах, хадгалах хөтөлбөрийн хүрээнд:

Говь-Шанхын уртын дууг түгээн дэлгэрүүлэх уралдаан



Говь нутгийн ард түмний оюуны баялаг өмч болсон уртын дууны гайхамшигийг эртний уламжлалт дэг жаягийнх нь дагуу хадгалах, сэргээх, залуу хойч үеийнхэнд өвлүүлэн үлдээх зорилгоор Говь шанхын уртын З дууг сэргээн өвлүүлэх ажлыг санаачилж, уртын дууны наадмыг гурав дахь жилдээ Өмнөговь аймгийн Цогцэций суманд амжилттай зохион байгууллаа. 2012 онд уралдааныг насанд хүрэгчдийн ба

хүүхдийн гэсэн хоёр ангиллаар зохион байгуулж нийт 21 хүүхэд, 12 насанд хүрэгчид буюу нийт 33 уртын дуучид оролцлоо. Уралдаанд 8 сумын уртын дуучин оролцсон нь уралдааныг улам өрсөлдөөнтэй болгосон юм.

Галбын улаан тэмээний баяр

Орон нутгийн иргэдийн санаачилгаар Энержи Ресурс компанийн дэмжлэгтэйгээр 2012 оны 3-р сарын 18-ний өдөр Ханбогд сумын Жавхлант багийн нутагт “Галбын улаан тэмээний баяр”-ыг зохион байгууллаа. Компанийн зүгээс говь нутгийнхны амьдралын хэв маягийн салшгүй хэсэг болох тэмээ маллах зан үйлийг хойч үеийнхэнд өвлүүлэх, цаашид мал аж ахуй эрхлэх сонирхлыг нь төрүүлэх чухал ач холбогдолтой арга хэмжээ хэмээн үзэж, соёлын өвийг хадгалах, хамгаалах бодлогынхоо хүрээнд дэмжин хамтран ажиллалаа.



“Цэций жонон” хуурын татлагыг түгээн дэлгэрүүлэх санаачлага

Цэций жононгийн хуурын татлага нь Өмнөговь аймаг тэр дундаа Шанхын нутгийн хурдан хүлгийг магтан дуулсан нутгийн өв болсон аялгүүт татлага билээ. Өдгөө энэхүү Цэций жононгийн хуурын татлагыг мэддэг, хуурдаж чаддаг хүн цөөн үлдсэн. Компаниас энэхүү соёлын үнэт өв болсон хуурын татлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Дундговь аймгийн морин хуурч, МУСТА н.Нэргүйтэй хамтран ажиллаж эхэлсэн. Цэцийн жононгийн аялгууг өвлүүлж, “Төв халхын жонон” нэртэй бие даасан бүтээлийг ЮНЕСКО-д бүртгүүлж чадсан энэхүү нэрт хуурчтай хамтран ажиллаж, сургалт зохион байгуулснаар Төв халхын жонон аялгууг аймаг, сумдын мэргэжлийн хуурчдад бүрэн эхээр нь зааж, цаашид хүүхэд багачуудад түгээн дэлгэрүүлэх сайхан боломж бүрдэж байна.



Ухаа худаг наадам -2012

Үндэсний баяр наадам нь монголчуудын түүх, соёлыг харуулсан чухал баярын нэг төдийгүй соёлын биет бус өв уламжлалын эх сурвалж байдаг билээ. Энержи Ресурс компани нь Өмнөговь аймгийн Цогтцэций суманд Ухаа худагийн уурхайд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн цагаас нутгийн иргэдэд үйл ажиллагаагаа таниулах, нээлттэй ил тод байдлыг эрхэмлэн ажиллаж ирсэн билээ, Тиймээс жил бүр Ухаа худгийн наадмыг зохион байгуулж үйл ажиллагааныхаа үр дүн, амжилтаа хэлэлцэн нутгийн иргэдтэйгээ хамтран тэмдэглэдэг уламжлалтай болсон. 2012 оны 8-р сарын 17-ны өдөр зохион байгуулагдсан Ухаа Худаг наадамд нутаг нутгийн хүчинтэй бөхчүүд, алдарт уяачид, эрхий мэргэн харваачид ирж өрсөлдсөн

нь наадмын цар хүрээ жилээс жилд өргөжиж, бус нутгийнхны хүсэн хулээдэг арга хэмжээ болж чадсаныг илтгэж байлаа. Мөн наадамчин олны дундаас сайхан морьтой, сайхан хос шалгаруулж шагнан урамшуулдаг нь ч мөн л монгол түмний эртний дээл, гоёл, хувцас хэрэглэлийн уламжлалыг сэргээх зорилготой бөгөөд өдгөө Ухаа Худаг наадмын сонирхолтой нэгэн тодотгол болж чадсан.



Уйгаржин монгол бичгийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр

Энержи Ресурс компаниас уйгаржин монгол бичгийг түгээн дэлгэрүүлэх талаар онцгойлон анхаарч, жил бүр тодорхой ажлууд зохион байгуулсаар ирсэн. 2012 оны хувьд, өсвөр үе ирээдүй болсон сурагчдын дунд Монгол бичгийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, цаашид сонирхон суралцах хүсэл сонирхлыг нь төрүүлэх зорилгоор Монгол бичгийн уран бичлэгийн сургалт явууллаа. “Монголын сурагчдын эрдмийн хүрээлэн” ТББ-тай хамтран 2012 оны 10-р сарын 15-ны өдрөөс 11-р сарын 15-ны хооронд зохион байгуулсан Монгол бичгээр уран бичих калиграфийн анхан шатны техник эзэмших сургалтанд Улаанбаатар хотын сурагчдын төлөөлөл болсон 75 хүүхэд шалгаран хамрагдсан.



Уг сургалтыг Монголын Хүүхдийн ордны Монгол бичгийн уран бичлэгийн багш нар болон Хэл Иргэншлийн дээд сургуулийн уран бичлэгийн багш нар заасан төдийгүй уг сургалтанд хамрагдсан 48 хүүхдийг дунд шатны техник эзэмших сургалтанд хамруулж эхэлсэн. Түүнчлэн уг санаачлагын хүрээнд суралцагч хүүхдүүдийн уран бүтээлийн үзэсгэлэнг зохион байгуулах, “Би Монгол Хүн” уран бичлэгийн клубыг нийслэлийн ерөнхий боловсролын сургууль бүрт байгуулах юм байна.

Жижиг дунд үйлдвэрлэл, малчдын тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

Ойн зурvas-тариаланг хөгжүүлэх төсөл

Байгаль орчныг хамгаалах зорилгоор 15 га ойн зурvas тарих төслийг хоёр дахь жилдээ хэрэгжүүлж байгаа билээ. Уг зурvas нь цөлжилт, элсний нүүдэл, тоосжилтыг бууруулахаас гадна, тариан талбайг салхинаас хамгаалах юм. Энержи Ресурс компанийн санхүүжилтээр Цогтцэций сумын Наймантын хөндийд байгуулсан энэхүү ойн зурваст өнгөрсөн жил 5 га

газарт говийн хайлаас, жигд, буйлс зэрэг модлог ургамал тариалсан бол энэ жил нэмж дахин 5 га талбайд 6000 ширхэг мод тарьсан ба нийт 10 га ойн зурваст 12500 ширхэг мод тариад байна. Төслийн хүрээнд ийнхүү олон мянган мод тариалж, говийн экологийн тэнцвэрийг хадгалахад хувь нэмрээ оруулж буй явдалд талархаж, Өмнөговь аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын газраас тус компанид “Ногоон өргөмжлөл” гардуулсан.

Ургацын баяр

Цогтцэций сумын Наймантын хөндийд байгуулсан салхины хамгаалалт бүхий ойн зурваст 3 га-д усалгааны систем бухий талбай тусгайлан гаргаж, орон нутгийн иргэдийг төмс, хүнсний ногоо тариалах, малын тэжээлийн эрдэнэшишийн талбай байгуулах боломжийг бүрдүүлээд байна. Энэхүү талбайд орон нутгийн 70 гаруй өрх хүнсний ногоо тариалсан нь энэ жил хангалттай сайн ургац өгч, компанийн хамт олон, нутгийн иргэдтэй хамтран говь нутагт ургацын баяр тэмдэглэлээ. Мөн эдгээр тариаланчдад хүнсний ногоо тариалалт, арчлалт, хураалт, даршлалт зэрэг хэрэгцээтэй сургалтуудыг үе шаттай зохион байгуулж байна.



Малчдын тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр

Компани нь үйл ажиллагаа эрхэлж буй орон нутагтаа нийгмийн нөлөөллийн судалгаа, мониторингийг тогтмол хийж, иргэдийн дуу хоолойг сонсч нийгмийн төсөл хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлдэг билээ.

Өмнөговь аймгийн зүүн бүсийн уул уурхайн хөгжил нь нутгийн иргэдийн мал аж ахуй, газар тариалан эрхлэлттэй хослон хөгжих боломжийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах улмаар уламжлалт бэлчээрийн мал аж ахуй болон хагас эрчимжсэн мал аж ахуйг хослуулах, мал сүргийн бүтцийг чанаржуулах, төмс, хүнсний ногооны тариалалтыг дэмжсэнээр өрхийн хүнсний баталгаат байдлыг хангаж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх цаашилбал орон нутгийн жижиг



дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжихөд дэмжлэг үзүүлэх зорилгоор малчдын тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж байна.

Малчин өрхийн нийгэм, эдийн засгийн байдлын судалгаанд уул уурхай, зам тээврийн нөлөөэллийн бүс, нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан өрхүүдийг хамруулсан бөгөөд Өмнөговь аймгийн Цогцэций, Баян-Овоо, Ханбогд сумдын нийт 64 өрх хөтөлбөрт хамрагдаж байна. Судалгаанд үндэслэн малчин өрхүүд мал аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжтойг тодорхойлсон бөгөөд малчдын хамтын оролцоог хөгжүүлэх, байгалийн нөөцийн хамтын менежментийг хөгжүүлэх, мал аж ахуйг эрчимжүүлэх, мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэлэмжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр хөтөлбөрт тусгасан.

Хөтөлбөрийн хүрээнд 2012 онд малчин өрх нэг бүртэй уулзалт зөвлөгөөн хийж малчин өрхийн өнөөгийн эрхэлж байгаа аж ахуйн төрөл, нөхцөл байдлыг тодорхойлж, малчдын өөрсдийнх нь санал болгож буй сонгосон аж ахуй хэлбэрийн талаарх мэдлэг, ур чадварыг нь нэмэгдүүлж, чадваржуулах сургалтуудыг төлөвлөн зохион байгуулах, мэдээлэл гарын авлага, тараах материал бэлтгэх мөн хөдөлмөрөөрөө хорших, хамтран ажиллах үүсгэл санаачлага, сонирхолыг дэмжих уулзалт зөвлөгөөн, сургалт зэрэг ажлуудыг зохион байгууллаа. Үүнд ноос хагас ба бүтэн боловсруулах, хавтгай аргаар эсгий хийх, битүү аргаар эсгийрүүлэх, ширмэлийн хээ зурах, нойтон аргаар хээставих, Монголчуудын урлахуй ухаан ба арга билгийн хослол зэрэг сургалтууд болон “Хонины ноос боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх”, “Малын үржил селекц” түүнчлэн “Бизнес эрхлэлт, бизнесийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” зэрэг сургалтуудыг зохион байгуулсан. Мөн хөтөлбөрт хамрагдсан малчин өрх нэг бүртэй уулзаж тогтвортой амьжиргааны арга замууд болон бизнес санаануудыг тодорхойлж тэдгээрт дүн шинжилгээ хийж сонголт хийхэд зөвлөн туслаж хамтран шийдвэрлэсэн бөгөөд одоогоор 54 өрх цаашид эрхлэх бизнесийн чиглэлээ сонгосон бөгөөд 47 өрх бизнесийн төлөвлөгөөтэй болоод байна.

Өвс тэжээлийн тусlamж



Хүйтний эрч чангач цаг зуурын бэрхшээлийг давах хүндхэн цаг үе малчдад тулгардаг. Ялангуяа.gov нутагийн малчдад хур бага, ган их мөн уул уурхай, зам тээвэр, тоосжилт гээд баагүй бэрхшээл тулгарч байдагт анхаарч Компаниас малчин өрхүүдэд өвс тэжээлийн тусламж үзүүлэх ажлыг дөрөвдэхь жилдээ зохион байгууллаа.

Өвс тэжээлийн тусламжийг Цогцэций, Ханбогд, Баян-Овоо, Ханхонгор сумдын 398 малчин өрхөд нийт 9050 боодол өвс, 2910 шуудай хивэг, 2181 шуудай хорголжин тэжээл өглөө.



14200 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг
Сэнтрал Тауэр, 16 давхар
Утас: (976) 70122279, 70132279
Факс: (976) 11-311196